



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 16,712,439,280.18 (арван зургаан тэрбум долоон зуун арван хоёр сая дөрвөн зуун гучин есөн мянга хоёр зуун наян төгрөг арван найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчит байгууллага болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Чингис хаан музейн захирал, академич С.Чулуун, хавсралтад заасан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ
132005607
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны № дугаар сарын 13-ны өдрийн
314 дугаар тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон,
төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	Соёлын төвийн барилга /Архангай, Чулуут сум/	2022.07.06	1,478,277,192.00	ББАОКД-2022/16	Архангай аймаг, ОНӨГ
2	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Дэлүүн сум/	2022.12.16	1,549,740,425.00	19/2022	Баян-Өлгий аймаг, ОНӨГ
3	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Шинэжинст сум/	2020.03.19	191,600,000.00	2020/11	Баянхонгор аймаг, ОНӨГ
4	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баянлиг сум/	2021.12.30	89,338,187.00	2021/54	Баянхонгор аймаг, ОНӨГ
5	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	2021.08.12	98,603,300.00	2021/17	Баянхонгор аймаг, ОНӨГ
6	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	2021.12.06	1,746,740,687.00	2021/29	Баянхонгор аймаг, ОНӨГ
7	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Цогт сум/	2020.11.24	320,104,955.00	КД-81/2020	Говь-Алтай аймаг, ОНӨГ
8	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Баян-Уул сум /	2022.12.26	1,831,306,911.00	КД-59/2022	Говь-Алтай аймаг, ОНӨГ
9	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Матад/	2022.09.12	829,446,750.18	ЗГ-03/2022(ОНТ-2.1.1)	Дорнод аймаг, ОНӨГ
10	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	2021.12.15	90,834,345.00	95/2021	Дорнод аймаг, ОНӨГ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
11	Соёлын төвийн барилга, соёлын заал, 400 суудал, номын сан, 45 суудал /Дундговь, Эрдэнэдалай сум/	2021.12.01	641,828,238.00	19/2021	Дундговь аймаг, ОНӨГ
12	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Идэр сум/	2022.10.20	1,699,799,980.00	22/2022	Завхан аймаг, ОНӨГ
13	Төв Азийн түүх соёлын өлгий Орхон, Тамир, Хануй, Хүнүйн соёлын өвийг судлах, сурталчлах мэдээллийн төв /Өвөрхангай/	2022.08.03	1,366,006,276.00	ББАОК-2022/08	Өвөрхангай аймаг, ОНӨГ
14	Соёлын төвийн барилга, 240 суудал, /Өвөрхангай, Баянгол сум/	2021.10.29	1,023,456,789.00	БУЗ3/2021	Өвөрхангай аймаг, ОНӨГ
15	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Ноён сум/	2020.07.30	101,460,719.00	У-2020/51	Өмнөговь аймаг, ОНӨГ
16	Орон нутаг судлах музейн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2021.09.02	611,705,934.00	26/2021	Хэнтий аймаг, ОНӨГ
17	Чингис хаан музейн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021.12.24	3,042,188,592.00	БА-287/2021	Чингис хаан музей
	НИЙТ ДҮН		16,712,439,280.18 (арван зургаан тэрбум долоон зуун арван хоёр сая дөрвөн зуун гучин есөн мянга хоёр зуун наян төгрөг арван найман мөнгө)		